

БОДЬ МӨРИЙН ГУРВАН ЭРХЭМ

/Ламзо нам сүм/

Богд тойн багш нарт мөргөмүй.

Ялагчийн эрхэм зарлиг бүхний гол утга
Ялагч хөвгүүн дээдэс нарын сайшаасан мөр
Хувь төгөлдөр гэтлэхийг хүсэгчдийн орох олом түүнийг
Хэр чадлаараа ямар мэт би бээр номлож үйлдэе.

Хэн нэгэн сансарын амгаланд үл тачаах хийгээд
Чөлөө учралын хэргийг гаргахын тул хичээж
Бурханыг баясгах мөрд сэтгэл итгэмжилсэн
Хувь төгөлдөр тэдгээр тунгалаг сэтгэлээр сонс.

Асар ариун магад гарахуй үгүйгээр сансарын далайн
Амгалангийн үрийг хүсэвч амирлах арга байхгүй
Бүхий л сансарт шунасанаар амьтан бүгд
Бүхнээс хүлэгдсэн тул анхлан магад гарахуйг эрэлхийл.

Чөлөө учрал олоход бэрх, насанд зав чөлөөгүйг
Чандлан сэтгэлдээ дадуулснаар энэ насныг шуналыг буцаа
Үйлийн үр хуурмаггүй, орчлонгийн зовлонгуудыг
Ахин дахин санаваас хойдын шунал буцна.

Тэр мэт дадуулснаар орчлонгийн хотол чуулганд
Торгоцох сэтгэл агшин төдий ч үл төрөх хийгээд
Өдөр, шөнө бүхэнд гэтлэхийг хүссэн оюун
Үргэлжлэн гарваас тэр цагт магад гарахуй төрнө.

Магад гарахуй тэр нь ч нэн ариун бодь сэтгэлээр
Машид эс эзлэгдвээс дээр үгүй бодийн
Амгалан хотол чуулганы уг үл болох тул
Оюун төгөлдөр нар бодийн сэтгэлийг үүсгэ.

Асар хүчтэй дөрвөн мөрний урсгалд автаж
Эргүүлэхэд хэцүү үйлийн чанга хүлээсээр хүлэгдэж
Би-д барихын төмөр торны дотор хоригдон
Балар мунхагийн харанхуй бүхнээр бүрхэгдээд
Эцэс төгсгөлгүй сансарт төрлөөс төрөл дамжин
Үргэлж тасралтгүйгээр гурван зовлонгоор нэрвэгдсэн
Ахуй үес энэ адил болсон ээжүүдийнхээ
Авир ёсыг санаад сэтгэлийн дээдийг үүсгэн зохио.

Орших ёсыг оносон билгүүн үгүй аваас

Уйсахуй, бодь сэтгэлийг дадуулан үйлдсэн ч
Төвөгт сансарын ёзоорыг таслаж үл чадмуй
Тиймийн тул шүтэн барилдлагыг онох арганд шамд.

Аливаа орчлон, нирвааны юмс үзэгдэл бүгдийн
Уг үр нь хэзээ ч хуурмаггүйг үзэх хийгээд
Зоригдлын зогсоол алин бүгдийг эвдвээс
Тэр нь бурханыг баясгах мөрд орох мөн.

Хуурмаггүй шүтэн барилдлагат үзэгдэл хийгээд
Хоосныг хүлээн зөвшөөрөх хагацсан ойлгоц хоёр
Хэдий чинээ тусдаа үзэгдэх төдийг хүртэл
Эдүгээ Чадагчийн тааллыг мэдэх үгүй.

Сая л нэг сөөлжих (зөрчилдөх) үгүйгээр нэгэн зэрэг
Шүтэн барилдлага хуурмаг үгүйг үзэх төдийгөөр
Магад мэдэл орны баригдах байдал бүхнийг эвдвээс
Магадтай тэр цагт үзлийн ажиглал гүйцэх болно.

Басхүү үзэгдлээр буйн хязгаарыг арилгах болон
Байхгүйн хязгаарыг хоосноор няцаах ба хоосон ямагт
Уг хийгээд үрд ургах ёсыг мэдвээс
Эцэслэн барих үзлээр булаагдахгүй болмуй.

Тэр мэт мөрийн гурван эрхэм зүйлийн
Оньюудыг өөрөө ямарчлан мэдэхийн цагт
Аглагыг шүтэн хичээнгүйн хүчийг үүсгээд
Ашидын хэргээ түргэн бүтээгтүн хүү минь!